



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/416

Булган сум

**“Анхдагчдын хаалга”-ыг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дах заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны VIII/55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн 80 жилийн ойн хүрээнд хандиваар хийгдсэн “Анхдагчдын хаалга”-ыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын
Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Б.Ганчулуун (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

Д.Отгон (Булган аймгийн уугуул иргэн)

З.Батбагана (Булган сумын Засаг даргын орлогч)

Ц.Даваадорж (Булган сумын Тохижилт
үйлчилгээний ангийн дарга)

2. “Анхдагчдын хаалга”-ыг хүлээн авч, зураг, төсөв, гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээний үнийн дүнд үндэслэн данс бүртгэлд бүртгүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга), урсгал засварын төсвийг сумын төсөвт тусгаж ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

